ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,908,354.22	89.5	1,581,863.4	86.0	(326,490.9)	(17.1)
Үндсэн хөрөнгө	2,725,489.03		2,779,603.0		54,114.0	2.0
Хуримтлагдсан элэгдэл	(817,134.82)		(1,197,739.7)		(380,604.9)	46.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,131,649.9	100.0	1,838,372.3	100.0	(293,277.6)	(13.8)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,131,649.94	100.0	1,837,214.3	100.0	(294,435.6)	(13.8)
Засгийн газрын хувь оролцоо	2,131,649.94		1,837,214.3		(294,435.6)	(13.8)
Нөөцийн сан					-	
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,131,649.9	100.0	1,838,372.3	100.0	(293,277.6)	(13.8)

Авлагын данс 1,100.0 мянган төгрөг болж өмнөх оноос 527.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Энэ нь 2021 онд Сипанс ХХК-аас үнэ төлбөргүй ирсэн хөрөнгөнөөс Лабораторийн барилгын агааржуулагч хоолой дутуу ирсэн нь Лабораторийн барилга баригдахаар хийгдэх тул авлагаар тусгасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 255,408.9 мянган төгрөг болж өмнөх оноос 33,740.9 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материалын данс 18,762.4 мянган төгрөгөөр нэмэгдэж голлох нөлөө үзүүлжээ.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 448,437.7 төгрөгийн бараа материал, үнэ төлбөргүй 701,510.3 мянган төгрөгийн бараа материалыг тус тус авч нийт 1,149,948.1 мянган төгрөгөөр орлогод бүртгэж 1,116,207.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,779,603.0 мянган төгрөг болж 55,114.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайланд онд газрын даргын тушаалын дагуу төсвийн хөрөнгөөр худалдаж авсан үнэ төлбөргүй шилжүүлэн авсан доорх хөрөнгүүдийг орлогод авсан нь үндсэн хөрөнгийн данс өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 2. Орлогод авсан хөрөнгийн жагсаалт

/мянган төгрөгөөр/

Үндсэн хөрөнгийн нэр	Тоо	Дүн	Шийдвэр
Тавилга, машин тоног төхөөрөмж	12	5,590.0	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан Газрын даргын 2024 оны А/50 тоот тушаал
Машин тоног төхөөрөмж	8	19,951.8	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан. Газрын даргын 2024 оны А/59 тоот тушаал
Машин тоног төхөөрөмж	3	8,582.2	ХХААХҮС-ын 2024 оны А/782 дугаар тушаалаар шилжүүлж авсан.
Авто машин	1	19,990.0	ИТХ-ын даргын захирамжаар Бууцагаан сумын ЗДТГ-аас фургон авто машин шилжүүлж авсан
Нийт	24	54,114.0	ИТХ-ын даргын захирамжаар Бууцагаан сумын ЗДТГ-аас фургон авто машин шилжүүлж авсан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,837,214.3 мянган төгрөг болж мянган төгрөг болж 294,435.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 294,435.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,301,016.9 мянган төгрөг, өөрийн орлогоор 2,500.0 мянган төгрөг, нийт зардлыг 2,303,516.9 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аудитын код: БНА-2025/113/НА-СТА-ТШЗ

Мал Эмнэлгийн ерөнхий газрын 2023 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн 01/1294 дугаартай албан бичгээр тус газрын төсвийг 1,586,292.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Албан бичигт анхааруулж төсвийн хуваарь 2024 оны 4 дүгээр сараас эхлэн үйлчилгээний салбарын албан хаагчдын цалин хөлс 40 хувиар, төрийн албан хаагчийн цалин хөлс 10 хувиар, орон нутгийн нэмэгдэл 40-20 хувиар олгож эхлэхтэй холбоотой нэмэгдүүлнэ гэсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,991,554.2 мянган төгрөг, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,164.7 мянган төгрөг нийт 1,994,718.9 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд зарцуулж 7,196.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 09 ний өдрийн 224 дугаар тушаалаар байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгож 1,419.1 мянган төгрөгийг давсан орлогоос зарцуулсан байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр арга хэмжээний код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүнгээр	Хувь
70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	1,106,747.7	1,106,747.7	-	100
70805	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага	902,827.0	895,167.5	7,659	99
	Нийт	2,009,574.7	2,001,915.2	7,659.5	96

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав. **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 1,587,830.7 мянган төгрөгийн санхүүжилт орж ирж гүйцэтгэлээр 1,587,459.5 мянган төгрөгийг зарцуулсан нь мал эмнэлгийн үйлчилгээний хөлсөнд голчлон зарцуулж 371.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Аудитын код: БНА-2025/113/НА-СТА-ТШЗ

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн мал эмнэлгийн газрын даргын 2024 оны Б/02 тушаалаар 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 6 төрлийн ажил үйлчилгээг худалдан авахаар баталжээ.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 36,280.5 мянга, гэрэл цахилгааны зардалд 2,102.2 мянга, цэвэр бохир усны зардалд 2,959.8 мянган төгрөг батлагдсанаас “Чандмань Баянхонгор” ХК-тай дулаанаар хангах, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээ, “Чандмань Баянхонгор” ХК-тай цэвэр бохир усны гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

Мөн Даталанд технологи ХХК тай гэрээ байгуулан тусгайлан хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төсвийн нэгдсэн системийн www.mafa.opengov.mn программ хангамжийг 7,200.0 мянган төгрөг, Биокомбинат ТӨХХК-тай гэрээ байгуулан 402,765.4 мянган төгрөгийн вакцин худалдан авах гэрээг тус тус байгуулж худалдан авалтыг хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 2,009,574.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 30,143.6 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг Аудитын код: БНА-2025/113/НА-СТА-ТШЗ

төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 21,000.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаар үйлчлэхгүй бөгөөд төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж тогтмол зардлын 96.2 хувийг зарцуулж 1,549,875.1 мянган төгрөгийг хэмнэж өр авлага үүсгээгүй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан мэдээлбэл зохих 158 гүйлгээний 4,711,646.7 мянган төгрөгийн мэдээллийг 100 хувь, 6.4.8 “Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэр”-ийн 44 шийдвэрээс 42 шийдвэрийн тус тус мэдээлж 4 шийдвэр мэдээлээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын өгсөн зөвлөмжийн мөрөөр тайлант онд Мал эмнэлгийн ерөнхий газар, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторитой гэрээ байгуулан 18,369.0 мянган төгрөгийн санхүүжилт авч Баянхонгор аймгийн хэмжээнд нийт 13,887 хээлтүүлэгч малаас 20 сумыг хамруулан 8,541 хээлтүүлэгч малд цусны дээж цуглуулж, нийт хамруулах хээлтүүлэгчийн 62 хувийг шинжилгээнд хамруулж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 28,532.2 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 1,432.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 27,190.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 19,990.0 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг бусаар тооцсон ба бусад зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 21,000.5 мянган төгрөгөөс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны Б/24 дугаар тушаалаар Ч.Дашнямд 2024 оны 06 дугаар сарын 24- ний өдрөөс эхлүүлэн 2024 оны 08 дугаар сарын 09 ний өдөр хүртэлх хугацаанд Солонгос улсад сургалтад суух зорилгоор цалинтай чөлөөг олгосон нь сургалтад хамрагдсан хугацаа тушаалын хугацаанаас зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5.5-д заасан “ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах ”, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 “харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын шинжээч эмч Ч.Дашнямд чөлөөтэй байх хугацаанд тооцон олгосон 1,432.2 мянган төгрөгийг Ч.Дашнямаар нөхөн төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн актыг тогтоов.

5.1 Албан шаардлага

5.2.1 Аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 07 сарын 28 ний өдрийн 67 дугаар захирамжаар Мал эмнэлгийн газарт Бууцагаан сумын ЗДТГ-аас БНХ 2949 улсын дугаартай фургон авто машин шилжүүлж авч нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн боловч авто машины гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байна

Энэ нь Авто тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх “Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Шилжүүлэн авсан БНХ 2949 улсын дугаартай фургон авто машиныг авто тээврийн газар бүртгүүлж эзэмшигчийг Мал эмнэлгийн нэр дээр шилжүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

5.2.2 Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн системтэй давхардуулан дахин шинэ систем болох Даталанд Технологи ХХК-тай "Программ хангамжийн www.mofa.open.gov.mn үйлчилгээний" гэрээ байгуулж үйлчилгээний төлбөрт жилийн 7,200.0 мянган төгрөгийг төлсөн байна. Тухайн төлбөр нь жил бүр давтан гарах шинжтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Газрын даргын 2024/07/01 ний өдрийн Б/24 дугаар тушаалаар Ч.Дашнямд цалинтай чөлөө олгосон нь Солонгос улсад суралцсан хугацаа тушаалын огноотой зөрүүтэй байна.	1	1,432.2	1	1,432.2								
Бууцагаан сумын ЗДТГаас 2024 оны 7 сард шилжүүлж авсан авто машины эзэмшигчийг шилжүүлж бүртгүүлээгүй.	1				1							
Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн системтэй давхардуулан дахин шинэ систем болох Даталанд Технологи ХХК-тай "Программ хангамжийн гэрээ байгуулсан.	1	7,200.0			1	7,200.0						
Дүн	2	8,632.2	1	1,432.2	1	7,200.0	0	-	0	0	0	0

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 20/А574255/БМА-2025/03 /
- МА-СТА-ТЗЦ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Баянхонгор аймгийн Мал Эмнэлгийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл”-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны Б/24 дугаар тушаалаар малын шинжээч эмч Ч.Дашнямыг Солонгос улсад сургалтад суухад 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс эхлүүлэн 2024 оны 08 дугаар сарын 09 ний өдөр хүртэлх хугацаанд цалинтай чөлөөг олгосон ба сургалтад хамрагдаж авсан сертификат олгосон хугацаа тушаалын хугацаанаас зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5.5-д заасан “ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 “харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5 “Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын шинжээч эмч Ч.Дашнямд чөлөөтэй байх хугацаанд олгосон 1,432.200 (нэг сая дөрвөн зуун гучин хоёр мянга

5050058

хоёр зуу) төгрөгийг Ч.Дашнямаар нөхөн төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2025 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн дотор Баянхонгор аймаг дахь¹ Төрийн аудитын газарт² ирүүлэхийг Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, нягтлан бодогч А.Номингэрэл нарт даалгав³.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР

Д.ДАВААДОРЖ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

² Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 34/АД571255/БНА-2025-
-113/НА-СА-ТМБ.

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 07 сарын 28 ний өдрийн 67 дугаар захирамжаар Мал эмнэлгийн газарт Бууцагаан сумын ЗДТГ-аас БНХ 29-49 улсын дугаартай фургон авто машин шилжүүлж авч нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн боловч авто машины гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байна.

Энэ нь Авто тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх "Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орлогод авсан БНХ 29-49 улсын дугаартай фургон авто машиныг авто тээврийн газар бүртгүүлж эзэмшигчийг Мал эмнэлгийн нэр дээр шилжүүлж нотлох

5040102

баримтыг 2025 оны 06 дугаар сарын 20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, нягтлан бодогч А.Номингэрэл нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Д.Д.ДАВААДОРЖ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 37/113/НА-СТАТУЗ
20571255161А-2025

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөвт байгууллагууд Сангийн яамны Төсвийн төлөвлөлтийн программыг үйл ажиллагаандаа үнэ төлбөргүйгээр ашиглаж байхад тус байгууллагын дарга “Даталанд технологи” ХХК-тай 2024 онд гэрээ байгуулан 7,200,000 (Долоон сая хоёр зуун мянган) төгрөгөөр тусдаа төсвийн нэгдсэн системийн программ авч үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Сангийн яамны Төсвийн төлөвлөлтийн системийг ашиглан санхүүгийн үйл ажиллагааг явуулж, дээрх үнэ төлбөртэй системийг ашиглахыг зогсоож

5040116

хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, А.Номингэрэл нарт даалгав^{2,3}.


АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Д.ДАВААДОРЖ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно